

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-12</i>
1. Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлт	<i>5-12</i>

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 03 дугаар сарын 24-ний өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 26 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Амарбаясгалан, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Б.Батбаатар, Ж.Баярмаа, Н.Номтойбаяр, Л.Мөнхбаатар;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Т.Доржханд, Л.Оюун-Эрдэнэ, Л.Гантөмөр, Л.Энх-Амгалан.

Нэг.Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, итгэмжлэгдсэн төлөөлөгч О.Номинчимэг танилцуулав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Г.Уянгахишиг нар үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 12

Бүгд: 13

7.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир үг хэлэв.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө

тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 11
Бүгд: 13
15.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшвэл хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 10
Бүгд: 13
23.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 11
Бүгд: 13
15.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “ ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 10

Бүгд: 13
23.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 11
Бүгд: 13
15.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 13
Бүгд: 13
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 13
Бүгд: 13
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 37 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 19 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим, 18 цаг 26 минут*

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны ирц үүссэн байна. Ирц бүрдсэн байна. Байнгын хорооны гишүүдийг хуралдааны танхимд хүрэлцэн ирэхийг урьж байна.

Одоогийн байдлаар Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдээс Оюунсайханы Алтангэрэл, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Сархадын Зулпхар, Одсүрэнгийн Номинчимэг, Эрдэнэбилэгийн Одбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Ням-Осорын Учрал, Гончигдоржийн Уянгахишиг, Одонгийн Цогтгэрэл, Өлзийхүүгийн Шижир гэсэн гишүүд хүрэлцэн ирээд байна. Гишүүдийг хуралдааны танхимдаа орж ирэхийг урьж байна.

Бас хажуу талын “Жанжин Сүхбаатар” танхимд Хууль зүйн байнгын хороо хуралдаад бас нэр бүхий гишүүд Хууль зүйн байнгын хорооны хуралдаан дээр бас суугаад байгаа юм байна. Хурлууд давхацчихаад, манай ажлын хэсгийнхэн, ажлын албаныхан гишүүдээ дуудаарай. Мөн зарим нэр бүхий гишүүд гадаадад томилолттой яваа юм байна. Ирцдээ орсон гишүүдийг хуралдааны танхимдаа орж ирэхийг урьж байна. Болормаа гишүүн, Бямбацогт гишүүн, Зулпхар гишүүн, Пүрэвдорж гишүүн, Туваан гишүүн, Учрал гишүүн, Цогтгэрэл гишүүн Шижир гишүүд ирцдээ орсон байна. Хуралдааны танхимдаа орж ирэхийг хүсэж байна. Хуралдааны танхимд Одбаяр гишүүн, Уянгахишиг гишүүн 2 орж ирээд байна. Хуралдааны танхимд Өлзийхүүгийн Шижир гишүүн орж ирсэн байна. Гишүүдээ дуудаарай. Хууль зүйн байнгын хороо дээр байгаа 4, 5 гишүүдийг гялс орж ирээдхээч гээд хэлээдхээч. Уг нь ганцхан хэлэлцэх асуудалтай шүү дээ. Уг нь бол гайгүй. Төрийн байгуулалтын байнгын хороонд харьяалагддаг гишүүд хуралдаа ирнэ үү. Ирцдээ орж ирчхээд, тэгээд хуруугаа уншуулчихаад тэгээд яваад байх юм. Ирцдээ орсон гишүүд хуралдааны танхимд орж ирэхийг урьж байна. 13 гишүүн ирцдээ орсон байна. Төрийн байгуулалтын байнгын хороо өнөөдөр 15 цагт товлөгдсөн 18 цаг 39 минут болж байна. 3 цаг 40 минут хүлээж байна.

Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 24-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны нээснийг мэдэгдье ээ. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 3 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/ асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 3 дугаар дүгнэлтийг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84.2.1 Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлаар санал, дүгнэлт гаргах гэж заасан. Ингээд Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 3 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, итгэмжлэгдсэн төлөөлөгч О.Номинчимэг гишүүн танилцуулна. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргаан дээр итгэмжилсэн төлөөлөгчөөр ажилласан. 2025 оны 2 сарын 26-нд тус хуралдаан болж, шийдвэр гарсан байгаа. Энэ маргаан яах вэ 2 янзын мэдээлэгчтэй байсан. 2 төрлөөс. 1 нь бол Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41.9, 44.6 дээр Улсын Их Хурлын гишүүд сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.

44.6-д энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэсэн 2 заалт байгаа.

Тэгээд энэ 2 заалтыг ерөнхийдөө Үндсэн хуулийн цэц дүгнэж авч үзээд, Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн. Энэ дүгнэлтийг хийхдээ 3 ерөнхийдөө шалгуурыг тавьж, цэц шийдвэрээ гаргасан байгаа. Энэ юу вэ гэвэл Улсын Их Хурлын гишүүд бол мэдээж ард түмний төлөөлөгч, сонгогдсон албан тушаалтнууд байгаа.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын хуулийн 8 дугаар зүйл дээр ч гэсэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх сонгогдож, тангараг өргөснөөр, дараагийн Улсын Их Хурлын бүрэн эрхийг сахих хүртэл ингээд бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Үүний дотор Улсын Их Хурлын гишүүд өөрсдийн сонгогчдодоо үйл ажиллагааны талаар мэдээлэх үүрэгтэй, эрхтэй гэсэн ийм зарчим байдаг. Энэ бол өөрөө ардчилсан сонгуулийн парламентын гишүүдийн хувьд иргэд сонгогчидтойгоо уялдаа холбоотой ажиллах, тэднийхээ дуу хоолойг төрийн бодлогод тусгахад хамгийн

чухал ийм үйл ажиллагааны нэг байдаг. Энэ үйл ажиллагааг бол Сонгуулийн хууль дээр тусгайлан сонгуулийн жил эхлэхэд явуулж болохоор заасан нь ерөнхийдөө хүний үндсэн эрхийг хязгаарлаж зөрчсөн байна гэж үзсэн.

1 дүгээр шалгуур үзүүлэлтийн хувьд энэ хууль тогтоомж ер нь ойлгомжгүй байна, тодорхой бус байна гэсэн дүгнэлт өгсөн. Энэ дээр яах вэ, итгэмжилсэн төлөөлөгчийн хувьд дараа нь би өөрийн байр сууриа бас илэрхийлье гэж бодож байна.

2 дугаарт бусад яах вэ, Улсын Их Хурлын гишүүний хувиар энэ үйл ажиллагааг хийх нь зүйтэй боловч бусад сонгуульд нэр дэвшихээр горилж буй этгээдүүд харьцуулахад давуу байдал олгосон, илүү Улсын Их Хурлын гишүүн биш иргэд, албан тушаалтны хувьд энэ сонгуулийн сурталчилгаа эхлэхэд гарааны давуу бус байдлыг үүсгэж байна. Тэгэхээр ер нь олон улсын туршлагын хувьд ч гэсэн бусад иргэдэд адилхан ийм боломжийг өгөх ёстой гэсэн 2 дугаар дүгнэлт байгаа. Энэ нь тэгш эрхийг хангах зарчмыг зөрчсөн. Тэгш эрхийг хангахын тулд ерөнхийдөө адилхан бас тайлангаа тавих иргэд, сонгогчидтой уулзах боломжийг нь нээж өгөх хэрэгтэй гэсэн ийм дүгнэлт байна.

3 дугаарт нь тусгайлан ингэж заасан нь бол ялгаварлан гадуурхсан заалт байна гэсэн дүгнэлтийг хийгээд, үндсэн эрхийг зөрчсөн ийм заалтууд байна гээд энэ хурал гарснаар энэ зүйл заалтуудыг түдгэлзүүлсэн байгаа.

Энэ дунд суудлын хуралдаанд 5 гишүүн оролцсон. Сонгуулийн хуулийг ерөнхийдөө бас цаашид боловсронгуй болгох тал дээр та бүхэн харсан бол Цэцийн дүгнэлт дээр нэлээн дэлгэрэнгүй байр суурийг бас илэрхийлсэн ийм дүгнэлт гарсан.

Ц.Сандаг-Очир: Танилцуулга хийсэн Номинчимэг гишүүнд баярлалаа. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Үг тусдаа шүү. Асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Асуулт алга байна. Асуултыг тасаллаа. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж дууссан. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Нэрээ өгнө үү. Үг хэлэх гишүүд. Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүний микрофон.

О.Номинчимэг: Яах вэ, гишүүний хувиар ч гэсэн, итгэмжилсэн төлөөлөгчийн хувиар ч гэсэн энэ дүгнэлттэй холбоотой бас хэд хэдэн юмыг хэлмээр санагдаж байгаа. Тухайн үед бол энэ хуралдаанд оролцоод мэтгэлцэх зарчмын хүрээнд тайлбараа хүргүүлсэн. Энэ дүгнэлт дээр байгаа бас зарим хэсгүүдтэй санал нийлэх, зарим хэсгүүдтэй санал нийлэхгүй байх ийм хэсгүүд байна. Ялангуяа нөгөө мэтгэлцээний үеэр хийсэн тайлбар болон Сонгуулийн ерөнхий хорооноос бас мэргэжилтний үүднээс, экспертний үүднээс бол танилцуулга тайлбаруудыг авсан байгаа. Тэгэхээр яах вэ, энэ дээр бол эхний нөгөө шалгуур буюу хууль тогтоомж нь өөрөө бас ойлгомжгүй байна, тодорхой байх ёстой гэдэг дээр уг нь бол өмнөх 2011 оны хуулиас илүү боловсронгуй болгоод, Улсын Их Хурлын гишүүн бол зөвхөн хийсэн ажлаа л тайлагнаж болно шүү гэдэг байдлаар уг нь бол оруулсан гэж Сонгуулийн ерөнхий хорооноос тайлбарласан боловч энэ цэцийн шийдвэр дээр энэ бас ингээд тухайн тайлбарыг авсан боловч их бүрхэг байдлаар тайлбаруудыг ерөөсөө дурдаагүй өнгөрсөн байгаа.

Тэгэхээр ер нь хэрвээ цэцийн дүгнэлтийг хүлээж авах тохиолдолд зөвхөн энэ 44.1, 44.6, 41.9-өөс гадна 48.1 буюу нөгөө хууль бус сурталчилгаанд юу тооцогдох вэ гэдэг асуудал ч гэсэн хамтдаа хөндөгдөж байгаа. Энэ дээр бол яг мэтгэлцээний үеэр бол энэ сонгуулийн жил эхэлснээс хойш энгийн иргэд ч гэсэн ямар нэгэн тэр 48.1 дээр заасан хориглох ажиллагаанаас бусад хэлбэрээр иргэд, хүмүүстэй уулзах, яриа хөөрөөгөө хийх энэ асуудал ерөөсөө хориглогдоогүй байгаа. Тэгэхээр энэ бол нээлттэй байгаа. Энэ бол зөвхөн Улсын Их Хурлын гишүүний хувьд ажлын тайлангаа хийж, урьд нь 2011 онд бол ажлын тайлан гэдэг нэрийдлээр эд мөнгө тараах янз бүрийн асуудал байсан бол энийг нь цэгцлээд Улсын Их Хурлын гишүүний хувьд бүрэн эрхийнхээ хэрэгжүүлэх хүрээнд зөвхөн хийсэн ажлынхаа тайланг тараах тэр зорилгоор уулзахад нь болно шүү гэдэг байдлаар ингээд оруулж өгсөн байгаа. Тэгтэл энийг зөвхөн эд нарт өгөөд бусдад нь өгөөгүй байна гэдэг байдлаар бас тайлбарласан байна. Цэцийн дүгнэлт дээр. Тэгэхээр энэ дээр бас яах вэ, хэрвээ тийм ойлгомжгүй, тодорхойгүй байгаа бол хууль тогтоомжийг боловсронгуй болгох гэдэг үүднээс яг нөгөө тайланд тавигдах шаардлагууд нь юу юм, хийсэн ажлын тайлан гэдэгт сонгуулийн сурталчилгааны агуулга ороогүй байх дээр ямар нарийвчилсан шаардлага гарах ёстой юм. Улсын Их Хурлын гишүүн биш хүний хувьд сонгогчдын саналыг татах зорилгогүйгээр нөгөө сонгуулийн компанит ажил буюу сонгуулийн сурталчилгаа эхлэхэд хийх ёстой ажлаас бусад байдлаар яаж иргэд, олон нийттэй уулзалт зохион байгуулж болох юм гэдгийг нь илүү нарийвчлаад оруулчих юм бол уг нь энэ зарчим нь бол байгаад байгаа юм. Тэгээд мэтгэлцээний ам мэтгэлцээний үеэр ч гэсэн энийг ярилцсан.

Тэгэхээр энэ тал дээр илүү тодорхой болгох юм бол тэр тэгш бус байдал байдаг юм уу, эсвэл ялгаварлан гадуурхсан гэдэг байдал маань өөрөө уг нь засагдчих боломжтой байна. Тэгэхгүй бол эхнийхээ тэр тодорхойгүй байна, нэгэнд нь давуу эрх олгочихсон байна гэдэг дүгнэлт дээр үндэслээд л ерөөсөө тэгш бус байдал байна. Дээр нь ялгаварлан гадуурхсан байна гэдэг дүгнэлтүүд бол Цэцийн дүгнэлт дээр гарсан байгаа. Тэгэхээр яах вэ, энийг тэр хууль тогтоомжоо илүүгүй боловсронгуй болгох эсвэл тодорхойгүй байгаа юман дээрээ, эсвэл эхний нөгөө үндэслэлээр нь хүлээж авах юм бол тодорхой боловсронгуй болгоё гээд зөвхөн хүлээж авах тохиолдолд хууль тогтоомж тодорхой байх, тодорхойгүй байгаа гэсэн энэ үндэслэлийг нь л хүлээж авах байдлаар явахгүй бол энэ маань өөрөө Цэцийн гарсан дүгнэлтүүд үүнтэйгээ холбоотой байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас гишүүд маань наанатай, цаанатай, өөрийнхөө бас байр суурийг илэрхийлээсэй гэж бодож байна. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмнийхээ элч төлөөлөгчийн хувьд бол байнга тайлагнах ёстой. Дээр нь .../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минут нэмж өгье.

О.Номинчимэг: Зөвхөн энэ зүйл заалтаар хязгаарлаад, Үндсэн хууль зөрчсөн гээд үзчих юм бол дараа дараагийн асуудал бас гарахаар байгаа. Энэ мэтгэлцээн дээр энийг хөндсөн боловч Үндсэн хуулийн цэцийн тайлбар дүгнэлтэд бол энэ ерөөсөө тусаагүй байна. Юу вэ гэхээр Улсын Их Хурлын гишүүн ийм байдаг юм байж, Засгийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар байгаа. Улс төрийн албан тушаалтан. Гэхдээ энэ төрийн ажил тасралтгүй үргэлжлэх ёстой. Тэр 1 сарын 1 эхэлсэн үү, эхлээгүй хамаагүй. Энэ бол төрийн ажил байгаад иргэд, олон нийтэд бодлогоо тайлбарлах, уулзалт зохион байгуулах асуудал угаасаа явагддаг. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд нь болохгүй байлаа гээд, тэгвэл Засгийн газрын гишүүд нь яах юм. Улс төрийн албан тушаалтан бусад төрийн ажиллагаа үргэлжилж байх, энэ үргэлжлүүлэн хийж байх ёстой албан

тушаалтны хувьд тэгээд дахиад бас давуу байдал үүсгэсэн гэдэг дүгнэлтэд хүрэх юм уу. Эд нарын хувьд албан тушаалаасаа болоод ийм ажлаа хийх ёстой байтал ялгаварлан гадуурхчихсан гэдэг бас үндэслэл рүү орох юм уу гэдэг асуудал бас яригдсан. Тэгэхээр энэ талаар бол энэ цэцийн дүгнэлт дээр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Тавигдаад, яах вэ ер нь бол зохицуулалт нь тодорхой бус, бүрхэг байгаа учраас илүү сонгуулийн хуулиа тодорхой болгох л асуудал үүсэж байгаа юм байна л гэж ойлголоо. Тийм ээ. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд бас яг тайлбарууд хэлэгдэж байна. Тийм ээ, энэ дээр бол Цэцийн гаргасан дүгнэлтийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Яагаад вэ гэхээр энэ өөрөө яг энэ сурталчилгааны материал хамаарахгүй, эсвэл яг энэ уулзалт нь энд хориглосон уулзалтад хамаарахгүй гэж ингэж оруулж ирж байгаа нь цаад утгаараа адил боловч энийг нь тусад нь зөвшөөрч байна гэдэг нөхцөл байдлыг үүсгээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ талаасаа бол буцаагаад ямар нэгэн байдлаар ялгаварлал үүсгэхгүй байх буюу давуу байдал үүсгэхгүй байх гэдгээр мөн Цэцийн дүгнэлт дээр ч гэсэн үндэслэх хэсэг дээр заасан байгаа. Нэг талаасаа ялгаварлахгүй байх, тэгш эрх эдлүүлэх, түүнчлэн Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагааны ил тод байдал эгэх хариуцлагыг хангахын тулд хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай гээд тусгачихсан байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол яг үнэндээ сонгуулийн үеэр ямар байдлаар энэ хуулийн заалтууд хэрэгждэг вэ. Их Хурлын гишүүд яг ямар байдлаар давуу эрх эдлээд байдаг вэ гэдгийг бид нар нэлээн сайн мэднэ шүү дээ практик хэрэглээнээсээ. Тэгэхээр одоо жишээлбэл сурталчилгааны материал тайлан гэхэд ийм том ном хэвлээд тараадаг.

Тайланг бид нар угаасаа 4 жилийн туршид төлөөлөгчийн хувьд иргэддээ, сонгогчидтойгоо байнгын эргэх холбоонд байгаа. Тийм ээ. Байнга тайлангаа гаргаж байгаа. Байнга уулзалтуудаа хийж, юу хийж байгаа гэдэг энэ бол өөрийнх нь эрхэд байж байгаа. Яг сонгууль дөхсөн үед буюу сонгуулийн жилд эхлээд байхад бусад нэр дэвшигчдийн хувьд дараа нь нөгөө тэр тайлан нэвтрүүлэгт орсон байлаа гэхэд тэрийг ашиглах боломжгүй болдог, уулзалт хийхэд дараа нь асуудал үүсэж орж ирдэг. Тийм ээ. Энэ нөхцөл байдлуудтайгаар ингээд яг адилхан байх зарчим дээр бид нар энэ сонгуулийнхаа хуулийг засах ёстой болж харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр яг Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлтийн үндэслэлтэй бол санал нэгдэж байна.

Харин үүнийхээ дараа Сонгуулийн хууль дээрээ яг энэ асуудлыг яаж жишээлбэл хугацаан дээр тодорхой болгох ёстой юу, эсвэл ерөөсөө энэ заалт байхгүй байлаа гээд сая итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хэлж байгаачлан угаасаа тэр үйл ажиллагаа нь нээлттэй байгаа юм уу. Энэ талаасаа бид нар нарийвчлан ярилцах ёстой байх гэж харж байна.

Ц.Сандаг-Очир: Боломж олгосон нь буруу биш, зүгээр тодорхойгүй бүрхэг байна л гэсэн үг. Сайд санал хураалт эхлэх гэж байна. Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84.2.2-т заасны дагуу Байнгын хороод цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг

зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулна гэж заасан. Санал хураалт явуулна. 8 санал хураалт байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Уянгахишиг гишүүн горимын санал гаргах юм уу. Зөвшөөрсөн дээр юм уу. Зөвшөөрлөө гээд тэгээд татгалзсан. Санал унасан. Дэмжигдсэнгүй. 1 дэх санал уналаа. Дэмжигдсэнгүй. 13 гишүүнээс 2 гишүүн дэмжиж, 11 гишүүн дэмжээгүй байна.

2 дахь санал хураалт. Шижир гишүүн үү. Саяын санал хураалттай холбоотой юу. Шижир гишүүн горимын санал гаргая гэж байна. Шижир гишүүний микрофон.

Ө.Шижир: Хуралдаан даргалагчаа энэ ирцдээ анхаарахгүй бол 8 санал чинь 8-уулаа унана. Тэгээд яг үндсэндээ энэ Төрийн байгуулалтын байнгын хороо чинь дандаа сайд, дарга нар байдаг. 1 нь ч алга. Одоо энэ Одбаяр сайд байна. Учрал сайд байна. Тэгээд хэрвээ энэ дээр улсын төсөв ярьж ... Алтангэрэл сайд орж ирж байна. Улсын төсөв, эсвэл томилгоо, ямар нэгэн бүтэц, зохион байгуулалт ярьсан бол сайд нар чинь бүгдээрээ сууж байгаа шүү дээ. Энэ сайд нараа дуудаач. Тэгэхгүй бол одоо энэ санал чинь бүгдээрээ унана шүү дээ. Тэгээд түрүүн тэр Хууль зүйн байнгын хороо дээр таны хэлдэг үнэн шүү дээ. Энд нь ийм Үндсэн хуулийн цэцийн асуудал дүгнэлт ярих болохоор ингээд гишүүд сайд нар нь байдаггүй. Тэгээд тэнд нь болохоор өөр хувь хүний улс төрийнхөө юмыг хийгээд яваад байдаг. Энэ ирцээ дуудахгүй бол, ирцээ хангахгүй бол энэ чинь бүгд уналаа. Нэг бол бүгдийг нь тэгээд унагаад явуулах юм уу. Цэцийн дүгнэлтийг авахгүй гээд.

Ц.Сандаг-Очир: Ирц хүрч байна л даа. Одоо яг хуралдааны танхимд 8 гишүүн хүрэлцэн ирсэн. 52 хувьтай байна. Тэгээд гишүүд үзэмжээрээ, ер нь бол Төрийн байгуулалтын байнгын хороонд сайд дарга нар олон байдаг гэдэг нь үнэн. Гэхдээ олонх сайд дарга нар томилолттой байгаа юм байна. Гадаадад. Өнөөдрийн хуралдаанд бол ирэх бололцоогүй юм байна. Боломжтой гишүүдээс бол ерөнхийдөө ирчхээд байгаа нь энэ байна.

Дараагийн 2 дахь санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай санал хураалтдаа оролцъё. 13 гишүүнээс 2 гишүүн зөвшөөрч, 11 гишүүн татгалзсан байна. 15,4 хувиар 2 дахь санал хураалт дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшвэл хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай санал хураалт даа ороорой. 3 гишүүн зөвшөөрч, 23,1 хувийн саналаар санал хураалт дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 2 гишүүн дэмжиж, 15,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

5.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “ ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 3 гишүүн дэмжиж, 23,1 хувиар санал хураалт дэмжигдсэнгүй.

6.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 2 гишүүн дэмжиж, 15,4 хувиар санал хураалт дэмжигдсэнгүй.

7.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Санал хураалт 100 хувийн саналаар тус санал хураалт дэмжигдсэнгүй.

8.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт 100 хувиар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Болормаа гишүүн, Уянгахишиг гишүүн, Шижир гишүүн, Одбаяр гишүүнд баярлалаа.

19.03 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ